



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

И-Монгол академи УТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2023/336/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он</p>	<p>Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: И.Эрдэнэцэцэг Утас: 261740 Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn Аудитор: О.Баярмаа Утас: 261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



И-МОНГОЛ АКАДЕМИ УТУГ-ЫН ЗАХИРАЛ
Б.МЯГМАРНАРАН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023.02.17 № 07/259
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу И-Монгол академи УТУГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол И-Монгол академи УТУГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

И-Монгол академи УТУГ нь Засгийн газрын 2021 оны 283 дугаар тогтоолоор үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад зайлшгүй шаардлагатай хөрөнгийг урсгал төсвөөс бэлтгэхдээ нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь багцалж тендер шалгаруулалт явуулаагүй, мөн нэр бүхий 1 аж ахуйн нэгжтэй "Ажил гүйцэтгүүлэх гэрээ"-г байгуулан засварын ажлын зураг төслийг хийлгэсэн боловч засварын ажил хийгдээгүй, үргүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

И-Монгол академи УТҮГ нь 2022 онд төрийн үйлчилгээний нэгдсэн e-mongolia.mn, үйлчилгээний байгууллагуудад зориулсан lavlagaa.e-mongolia.mn, төрийн байгууллагуудаас аж ахуйн нэгжид үзүүлж байгаа үйлчилгээг нэгтгэсэн e-business.mn вэб сайтууд болон ЗГХЭГ-ын хурлын e-cabinet зэрэг томоохон системийг шинээр хөгжүүлэн ашиглалтад оруулсан байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн e-mongolia.mn системд 71 төрийн байгууллагын 806 үйлчилгээг нэгтгэж, төрийн мэдээлэл солилцооны дундын ХУР, танилт нэвтрэлтийн ДАН, албан бичиг солилцох дундын ДОСх, төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ERP системүүдийн хөгжүүлэлт, хэвийн найдвартай ажиллагааг ханган шинэчлэлт, сайжруулалтыг хийсэн байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын захирлын тушаалаар баталсан "Албан тушаалын цалингийн шатлал, сүлжээ"-г мөрдөж байгаа нь холбогдох хууль, тогтоомжид заасантай нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

И-Монгол академи УТҮГ-ын захирлын 2022 онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтэд тусгасан 7 зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн 64 арга хэмжээг нийт 97.5 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн ба 3 арга хэмжээний гүйцэтгэл зорилтот түвшинд хүрээгүй байна. Тухайлбал:

1. Төрийн бүх салбарын серверийн талаар судалгаа хийх;
2. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны албан ёсны вэб хуудсыг монгол бичгийн хувилбараар хөгжүүлэх;
3. Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн ур чадварын бүтцийн хүрээг тодорхойлж, сургалтын хөтөлбөр боловсруулах;

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		93,367,295.26
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		16,052,483.50
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		16,052,483.50
31110	Төгрөг		16,052,483.50
35	БАРАА МАТЕРИАЛ		77,314,811.76
354	Хангамжийн материал		77,314,811.76
35410	Бичиг хэргийн материал		4,313,807.12
35420	Аж ахуйн материал		2,905,139.25
35440	Түлш, шатах тослох материал		67,150.00
35460	Хүнсний материал		801,570.00
35470	Бусад хангамжийн материал		69,227,145.39
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		551,338,110.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		551,338,110.04
392	Биет хөрөнгө		540,164,266.04
39205	Машин тоног төхөөрөмж		583,660,309.50
39206	Хуримтлагдсан элэгдэл		(135,149,726.03)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		84,427,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		(4,272,021.03)
39214	Бусад үндсэн хөрөнгө		13,209,230.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(1,711,026.40)
393	Биет бус хөрөнгө		11,173,844.00
39301	Програм хангамж		4,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(400,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө		31,595,376.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		(24,821,532.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		644,705,405.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		16,052,483.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		16,052,483.50
413	Өглөг		16,052,483.50
41361	Байгууллагад өгөх өглөг өгөх өглөг		16,052,483.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		628,652,921.80
51	Засгийн газрын хувь оролцоо		628,652,921.80
512	Хуримтлагдсан үр дүн		628,652,921.80
51220	Тайлант үеийн үр дүн		628,652,921.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		644,705,405.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		7,316,202,598.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		57,543,798.50
120	Нийтлэг татварын бус орлого		57,543,798.50
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		57,113,798.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		420,000.00
122001	Хандив тусламжийн орлого /дотоод/		10,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		7,258,658,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		7,258,658,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		7,258,658,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		6,687,549,676.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ		6,687,549,676.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,259,903,484.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,980,982,542.86
210101	Үндсэн цалин		1,722,549,957.99
210102	Нэмэгдэл		50,427,775.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт		94,020,311.42
210104	Урамшуулал		113,984,498.18
2102	Ажил олгогчоос нийгмийн НД-д төлөх шимтгэл		247,257,632.88
210201	Тэтгэврийн даатгал		168,244,098.50
210202	Тэтгэмжийн даатгал		19,793,423.37
210203	ҮОМШӨ-ний даатгал		15,830,148.68
210204	Ажилгүйдлийн даатгал		3,873,370.83
210205	Эрүүл мэндийн даатгал		39,516,591.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		270,752,634.01
210301	Гэрэл, цахилгаан		16,484,022.01
210304	Байрны түрээс		254,268,612.00
2104	Хангамж, бараа материалын зардал		116,290,112.24
210401	Бичиг хэрэг		42,356,811.88
210402	Тээвэр, шатахуун		7,584,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		32,443,130.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,944,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		31,962,170.36
2105	Нормативт зардал		2,520,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		2,520,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,925,800.00
210604	Урсгал засвар		1,925,800.00
2107	Томилолт, зочны зардал		43,796,900.00
210702	Дотоод албан томилолт		43,796,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		533,834,161.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		533,834,161.36
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		62,543,700.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		4,950,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		57,593,700.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,427,646,192.39
2132	Бусад урсгал шилжүүлэг		4,900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		4,900,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		3,422,746,192.39
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		3,422,746,192.39
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН		628,652,921.80

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН		7,275,131,283.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		16,472,483.50
120	Нийтлэг татварын бус орлого		16,472,483.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		16,052,483.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		420,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		7,258,658,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		7,258,658,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		7,258,658,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		6,707,260,787.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ		6,707,260,787.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,279,614,595.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,980,982,542.86
210101	Үндсэн цалин		1,722,549,957.99
210102	Нэмэгдэл		50,427,775.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт		94,020,311.42
210104	Урамшуулал		113,984,498.18
2102	Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл		247,257,632.88
210201	Тэтгэврийн даатгал		168,244,098.50
210202	Тэтгэмжийн даатгал		19,793,423.37
210203	ҮОМШӨ-ний даатгал		15,830,148.68
210204	Ажилгүйдлийн даатгал		3,873,370.83
210205	Эрүүл мэндийн даатгал		39,516,591.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		270,752,634.01
210301	Гэрэл, цахилгаан		16,484,022.01
210304	Байрны түрээс		254,268,612.00
2104	Хангамж, бараа материалын зардал		75,692,021.00
210401	Бичиг хэрэг		13,875,130.00
210402	Тээвэр, шатахуун		2,688,150.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		32,443,130.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,581,149.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйл		25,104,462.00
2105	Нормативт зардал		3,250,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		3,250,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		36,647,180.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		31,655,850.00
210604	Урсгал засвар		4,991,330.00
2107	Томилолт, зочны зардал		48,836,900.00
210702	Дотоод албан томилолт		48,836,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		584,850,161.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		584,850,161.36
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		31,345,523.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		31,345,523.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,427,646,192.39
2132	Бусад урсгал шилжүүлэг		4,900,000.00
213206	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал		4,900,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		3,422,746,192.39
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		3,422,746,192.39

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		567,870,496.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН		551,818,012.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		551,818,012.50
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		551,818,012.50
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		(551,818,012.50)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		16,052,483.50
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		16,052,483.50

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн			628,652,921.80	628,652,921.80
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	628,652,921.80	628,652,921.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,296,658,800.00	3,836,332,607.61	3,460,326,192.39	52.6
УРСГАЛ ЗАРДАЛ	7,296,658,800.00	3,836,332,607.61	3,460,326,192.39	52.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,253,758,800.00	3,831,432,607.61	3,422,326,192.39	52.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,500,288,000.00	1,980,982,542.86	2,519,305,457.14	44.0
Үндсэн цалин	3,910,288,000.00	1,722,549,957.99	2,187,738,042.01	44.1
Нэмэгдэл	411,731,400.00	50,427,775.27	361,303,624.73	12.2
Унаа хоолны хөнгөлөлт	178,268,600.00	94,020,311.42	84,248,288.58	52.7
Урамшуулал	-	113,984,498.18	(113,984,498.18)	-
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	573,786,100.00	247,257,632.88	326,528,467.12	43.1
Тэтгэврийн даатгал	390,174,500.00	168,244,098.50	221,930,401.50	43.1
Тэтгэмжийн даатгал	45,902,900.00	19,793,423.37	26,109,476.63	43.1
ҮОМШӨ-ний даатгал	36,722,300.00	15,830,148.68	20,892,151.32	43.1
Ажилгүйдлийн даатгал	9,180,600.00	3,873,370.83	5,307,229.17	42.2
Эрүүл мэндийн даатгал	91,805,800.00	39,516,591.50	52,289,208.50	43.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	390,810,200.00	270,752,634.01	120,057,565.99	69.3
Гэрэл, цахилгаан	44,982,500.00	16,484,022.01	28,498,477.99	36.6
Байрны түрээс	345,827,700.00	254,268,612.00	91,559,088.00	73.5
Хангамж, бараа материалын зардал	140,345,500.00	79,658,461.00	60,687,039.00	56.8
Бичиг хэрэг	13,916,600.00	13,875,130.00	41,470.00	99.7
Тээвэр, шатахуун	9,102,400.00	2,688,150.00	6,414,250.00	29.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	68,388,800.00	32,443,130.00	35,945,670.00	47.4
Хог хаягдал зайлуулах, мэрэгчдийг устгал	11,751,300.00	1,581,149.00	10,170,151.00	13.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	37,186,400.00	29,070,902.00	8,115,498.00	78.2
Нормативт зардал	15,427,600.00	3,250,000.00	12,177,600.00	21.1
Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,427,600.00	3,250,000.00	12,177,600.00	21.1
Эд хогшил, урсгал засварын зардал	841,280,000.00	501,760,586.50	339,519,413.50	59.6
Багаж, техник хэрэгсэл	544,360,000.00	496,769,256.50	47,590,743.50	91.3
Урсгал засвар	296,920,000.00	4,991,330.00	291,928,670.00	1.7
Томилолт, зочны зардал	62,994,700.00	48,836,900.00	14,157,800.00	77.5
Дотоод албан томилолт	62,994,700.00	48,836,900.00	14,157,800.00	77.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	680,665,500.00	667,588,327.36	13,077,172.64	98.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	680,665,500.00	667,588,327.36	13,077,172.64	98.1
Бараа үйлчилгээний бусад зардал	48,161,200.00	31,345,523.00	16,815,677.00	65.1
Бараа үйлчилгээний бусад зардал	48,161,200.00	31,345,523.00	16,815,677.00	65.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,900,000.00	4,900,000.00	38,000,000.00	11.4
Бусад урсгал шилжүүлэг	42,900,000.00	4,900,000.00	38,000,000.00	11.4
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,900,000.00	4,900,000.00	38,000,000.00	11.4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,296,658,800.00	7,275,131,283.50	21,527,516.50	99.7
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	16,052,483.50	(16,052,483.50)	-
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	420,000.00	(420,000.00)	-
Улсын төсвөөс санхүүжих	7,296,658,800.00	3,835,912,607.61	3,460,746,192.39	99.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	16,052,483.50	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
АЖИЛЛАГСДЫН ТОО	125	96	29	76.8
Удирдах ажилтан	9	9	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	113	85	28	75.2
Үйлчлэх ажилтан	3	2	1	66.7

Гурав. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 45,617.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 26,244.6 мянган төгрөгийн алдааг залруулж, алдааг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

3.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллага нь бичиг хэрэг, шуудан холбоо, интернэтийн төлбөр гэх мэт нийт 25,244.6 мянган төгрөгийн ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн байна.	2	45,617.7			1	26,244.6	1	26,244.6	1	25,244.6	1	25,244.6
Дүн	2	45,617.7			1	26,244.6	1	26,244.6	1	25,244.6	1	25,244.6

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 20,373.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 573.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 19,800.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 албан шаардлага хүргүүлсэн.

3.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Тайлант онд орон нутагт ажилласан албан томилолтын зардлаас 573.1 мянган төгрөгийн согтуурах унаа худалдан авсан.	1	573.1	1	573.1								
Нэр бүхий 1 аж ахуйн нэгжтэй “Ажил гүйцэтгүүлэх гэрээ”-г байгуулан засварын ажлын зураг төслийг 19,800.0 мянган төгрөгөөр хийлгэсэн боловч засварын ажил хийгдээгүй, үргүй зардал гаргасан.	1	19,800.0			1	19,800.0						
Эдийн засгийн зардлын ангилал зөрчиж дараах ажил гүйлгээг хийсэн байна. Үүнд: Зардлын ангилал 210801 ангиллаас 37,100.0 мянган төгрөгийн ширээ, сандлыг, 18,000.0 мянган төгрөгийн хувцас, зөөлөн эдлэлийг, 210901 ангиллаас 1,029.6 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг худалдан авсан.	1	-			1	-						
Тайлант хугацаанд сандал, ширээ, тавилгыг худалдан авахдаа нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь багцалж тендер шалгаруулалт явуулаагүй байна. Тухайлбал: Тэн Бий ХХК-тай 19,600.0 мянга, Ногоон Газар Бүтээмж ХХК-тай 19,800.0 мянга, Лока ХХК-тай 17,300.0 мянга, Баганат Биг Сервис ХХК-тай 17,300.0 мянга, нийт 74,000.0 мянган төгрөгийн тавилгыг шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн.	1	-			1	-						
Тайлант хугацаанд орон нутагт ажилласан албан томилолтоор ажиллахдаа 4 ширхэг суудлын автомашиныг өндөр үнэтэй түрээсэлж, нийт	1	-			1	-						

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

23,400.0 мянган төгрөгийг түрээсийн төлбөрт зарцуулсан байна.												
Дүн	5	20,373.1	1	573.1	4	19,800.0						

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 2 зөрчил илэрснээс бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

3.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	/мянган төгрөгөөр/						
			Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>									
1	Тус байгууллагын захирлын 2022 оны Б/01 дугаар тушаалаар баталсан "Албан тушаалын цалингийн шатлал, сүлжээ"-г мөрдөж байгаа нь холбогдох хууль, тогтоомжид заасантай нийцэхгүй байна.	1	-			1	-		
2	Мэдээлэл технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвартай инженерүүдтэй "Хөдөлмөрийн гэрээ"-г байгуулан цахимаар ажиллуулж, сар бүр гүйцэтгэсэн ажлыг дүгнэж цалин олгосон боловч цахимаар ажиллуулах талаар нарийвчлан зохицуулсан журам байхгүй байна.	1	-				1	-	
Дүн		2	-			1	-	1	